

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2021 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
6 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН  
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН  
ТОВЬЁГ**

<b>№</b>	<b>Хэлэлцсэн асуудал</b>	<b>Хуудасны дугаар</b>
<b>1.</b>	<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	1-37
<b>2.</b>	<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	38-206
	<b>1. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2021.06.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</b>	41-106
	<b>2. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2018.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</b>	106-132
	<b>3. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл болон “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/</b>	132-134
	<b>4. Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2019.08.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</b>	134-143
	<b>5. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/</b>	143-146
	<b>6. Кино урлагийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2019.04.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</b>	146-175
	<b>7. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг нарын 3 гишүүн 2020.09.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</b>	175-177
	<b>8. “Ардын хувьсгалын 100 жилийн ойн хүндэт медаль бий болгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2021.06.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</b>	177-184
	<b>9. “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2021.05.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</b>	184-206

## ***Хураангуй тэмдэглэл***

***Хоёр.Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2018.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, мөн яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Алимаа, Монголын Үйлдвэрчний Эвлэлийн холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга Г.Адъяа, Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбооны гүйцэтгэх захирал Х.Ганбаатар, Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхимын Ерөнхийлөгч О.Амартүвшин, мөн Танхимын Бодлого, стратегийн газрын дарга Ж.Оюунчимэг, Удирдлагын академийн багш, доктор (Ph.D) профессор Б.Уранцэцэг, хуульч н.Батнасан нар “Их хуралдай” танхимаас оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Э.Түвшинжаргал, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Батбаатар, мөн хэлтсийн референт Б.Мажигсүрэн, Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Нийгмийн бодлогын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил “Их хуралдай” танхимаас танилцуулав.

*Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 13 цаг 34 минутаас хуралдааныг даргалав.*

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, Д.Сарангэрэл, М.Оюунчимэг, С.Одонтуяа, Ц.Даваасүрэн, Х.Булгантуяа, Ж.Сүхбаатар, М.Оюунчимэг, О.Цогтгэрэл нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбооны гүйцэтгэх захирал Х.Ганбаатар нар хариулж, тайлбар хийв.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.*

**Нэг.Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол:**

**Г.Занданшатар:** 1.Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтын “хамтын сонирхлын маргааныг” гэснийг “хамтын

сонирхлын маргаан, эсхүл энэ хуулийн 25.2-т заасан хөдөлмөрийн эрхийн маргааныг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 45

Татгалзсан: 26

Бүгд: 71

63.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.16 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.16.“хөдөлмөрийн эрхийн маргаан” гэж хөдөлмөрийн хууль тогтоомж, бүх төрлийн хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг хэрэгжүүлэх, эсхүл эдгээр хэм хэмжээг тайлбарлахтай холбоотойгоор талуудын хооронд үүссэн саналын зөрүүг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47

Татгалзсан: 24

Бүгд: 71

66.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “Ажилтны төлөөлөгчид” гэсний өмнө “Ажилтан,” гэж, 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсгийн “зааснаас бусад тохиолдолд” гэсний дараа “ажил олгогч” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 45

Татгалзсан: 26

Бүгд: 71

63.4 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийн “сонирхлын” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил үг хэлэв.

Зөвшөөрсөн: 47

Татгалзсан: 24

Бүгд: 71

66.2 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 43 дугаар зүйлийн 43.2.9 дэх заалтын “хууль тогтоомжид заасны дагуу” гэсний дараа “ажлын байрны чиг үүрэгт хамаарах чиглэлээр” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт үг хэлэв.

Зөвшөөрсөн: 50  
Татгалзсан: 21  
Бүгд: 71  
70.4 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 63 дугаар зүйлийн 63.3 дахь хэсгийн “Дагалдангаар суралцах ажилтны” гэсний дараа “ажил олгогчоос болон ажилтнаас төлөх” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ үг хэлэв.

Зөвшөөрсөн: 42  
Татгалзсан: 29  
Бүгд: 70  
59.2 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсгийн “бүтээгдэхүүн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 46  
Татгалзсан: 24  
Бүгд: 70  
65.7 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 72 дугаар зүйлийн 72.3 дахь хэсгийн “үйлчлэх хугацаа” гэсний дараа “нь ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгавар болсноос хойш” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 46  
Татгалзсан: 24  
Бүгд: 70  
65.7 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 79 дүгээр зүйлийн 79.4 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 46  
Татгалзсан: 24  
Бүгд: 70  
65.7 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсгийн “ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцааг” гэсний дараа “энэ хуульд

зааснаас бусад үндэслэлээр” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48  
Татгалзсан: 22  
Бүгд: 70  
68.6 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 83 дугаар зүйлийн 83.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“83.5.Ажилтанд энэ хуулийн 83.3-т заасан хугацааны цалин хөлсийг ажил олгогч тооцож олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48  
Татгалзсан: 22  
Бүгд: 70  
68.6 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 85 дугаар зүйлийн 85.2 дахь хэсгийн “ажлын байранд” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49  
Татгалзсан: 21  
Бүгд: 70  
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 92 дугаар зүйлийн 92.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“92.5.Энэ хуулийн 92.4-т заасан хугацааг багасгах тохиолдолд ажил үүрэг гүйцэтгэх, амрах хугацаа нь тэнцүү байхаар ажил олгогч, ажилтны төлөөлөгч харилцан тохиролцож болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49  
Татгалзсан: 21  
Бүгд: 70  
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 99 дүгээр зүйлийн гарчгийн “Ээлжийн амралт” гэсний дараа “, түүний хугацаа” гэж, 99.3 дахь хэсгийн “ажилтны” гэсний өмнө “Хуульд өөрөөр заагаагүй бол” гэж тус тус нэмж, 99.3 дахь хэсгийн “ажлын 20 өдөр” гэснийг “ажлын 15 өдөр” гэж, 99.4 дэх хэсгийн “ажлын 25 өдөр” гэснийг “ажлын 20 өдөр” гэж, 99.9 дэх хэсгийн “Төрийн албан хаагчийн ээлжийн” гэснийг “Ажил мэргэжлийн онцлогийг харгалзан” гэж тус тус өөрчилж, 99.8 дахь хэсгийг хасаж, мөн зүйлийн 99.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“99.6.Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллаж байгаа ажилтанд түүний ажилласан хугацааг харгалзан ээлжийн үндсэн амралтын хугацаан дээр нь доор дурдсан нэмэгдэл амралтыг олгоно:

99.6.1. 6 дахь жилийн эхнээс 10 дахь жилийг дуусталх хугацаанд ажлын 5 өдөр;

99.6.2. 11 дэх жилийн эхнээс 15 дахь жилийг дуусталх хугацаанд ажлын 7 өдөр;

99.6.3. 16 дахь жилийн эхнээс 20 дахь жилийг дуусталх хугацаанд ажлын 9 өдөр;

99.6.4. 21 дэх жилийн эхнээс 25 дахь жилийг дуусталх хугацаанд ажлын 12 өдөр;

99.6.5. 26 дахь жилийн эхнээс 31 дэх жилийг дуусталх хугацаанд ажлын 15 өдөр;

99.6.6. 32 дахь жилээс ажлын 18 өдөр.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47

Татгалзсан: 23

Бүгд: 70

67.1 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 99 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 99.5 дахь хэсэг нэмэх:

“99.5.Хөдөлмөрийн хэвийн нөхцөлд ажиллаж байгаа ажилтанд түүний ажилласан хугацааг харгалзан ээлжийн үндсэн амралтын хугацаан дээр нь доор дурдсан нэмэгдэл амралт олгоно:

99.5.1. 6 дахь жилийн эхнээс 10 дахь жилийг дуусталх хугацаанд ажлын 3 өдөр;

99.5.2. 11 дэх жилийн эхнээс 15 дахь жилийг дуусталх хугацаанд ажлын 5 өдөр;

99.5.3. 16 дахь жилийн эхнээс 20 дахь жилийг дуусталх хугацаанд ажлын 7 өдөр;

99.5.4. 21 дэх жилийн эхнээс 25 дахь жилийг дуусталх хугацаанд ажлын 9 өдөр;

99.5.5. 26 дахь жилийн эхнээс 31 дэх жилийг дуусталх хугацаанд ажлын 11 өдөр;

99.5.6. 32 дахь жилээс ажлын 14 өдөр.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49  
Татгалзсан: 21  
Бүгд: 70  
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 104 дүгээр зүйлийн 104.7 дахь хэсгийн “цалин хөлс, олговрыг” гэсний дараах “олгоогүй, эсхүл” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48  
Татгалзсан: 22  
Бүгд: 70  
68.6 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 107 дугаар зүйлийн 107.2 дахь хэсгийн “хамтын хэлэлцээрээр зохицуулна” гэснийг “хамтын хэлэлцээрээр зохицуулж болно” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48  
Татгалзсан: 23  
Бүгд: 71  
67.6 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 123 дугаар зүйлийн 123.7 дахь хэсгийн “Ажил олгогч сахилгын зөрчлийн шинж, үр дагаврыг харгалзан энэ хуулийн 114.1 дэх хэсэгт заасан сахилгын шийтгэлийг сонгож хэрэглэнэ.” гэсэн 2 дахь өгүүлбэрийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 46  
Татгалзсан: 25  
Бүгд: 71  
64.8 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 154 дугаар зүйлийн 154.11 дэх хэсгийн “эсхүл шийдвэрийг” гэснийг “эсхүл шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш” гэж өөрчилж, мөн хэсгийн “хүлээн авснаас хойш” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52  
Татгалзсан: 19  
Бүгд: 71  
73.2 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 166 дугаар зүйлийн 166.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”  
гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50  
Татгалзсан: 21  
Бүгд: 71  
70.4 хувийн саналаар дэмжигдлээ.

**Хоёр. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт  
өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын  
томьёолол:**

**Нэг.Төрийн албаны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт, өөрчлөлт  
оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын  
томьёолол:**

**Г.Занданшатар:** 1.Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн “Төрийн  
албан хаагчид олгох ээлжийн нэмэгдэл амралт” гэсэн 61<sup>1</sup> дүгээр зүйлийг хасах гэсэн  
саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 46  
Татгалзсан: 25  
Бүгд: 71  
64.8 хувийн саналаар дэмжигдлээ.

**Хоёр. Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай  
хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын  
томьёолол:**

**Г.Занданшатар:** 1.Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуульд өөрчлөлт оруулах  
тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн  
санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50  
Татгалзсан: 21  
Бүгд: 71  
70.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн  
мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Нийгмийн  
бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 14 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.*

***Дэлгэрэнгүй тэмдэглэл***

***Хоёр.Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2018.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Мөнх-Оргил танилцуулна. Индэрт урьж байна. Таныг.

**Ц.Мөнх-Оргил:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2018 оны 3 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2021 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн.

Нийгмийн бодлогын байнгын хороо 2021 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаараа Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан явуулсан болно.

Нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас төслийн зарим зүйл, хэсэг, заалтыг гүйцээн боловсруулж, хуулийн төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулах чиглэл өгсний дагуу ажлын хэсгээс уртын ээлжээр ажиллах ажилтны ээлжээр ажиллах хугацааг богиносгох тохиолдолд ажил үүрэг гүйцэтгэх, амрах хугацаа нь тэнцүү байхаар, ажил олгогч, ажилтны төлөөлөгч харилцан тохиролцох, үйл өрсөлдөх гэрээний үйлчлэх хугацаа, хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дууссанаас хойш нэг жилээс илүүгүй байх, ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцааг энэ хуульд зааснаас бусад үндэслэлээр ажил олгогчийн санаачилгаар цуцлахыг хориглох зэрэг зарчмын зөрүүтэй 3 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн хуулийн төслийн зарим заалтаар болон Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатараас ирүүлсэн саналуудын талаар дахин санал хураах шаардлагатай гэж ажлын хэсэг үзсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёрын саналаар санал хураалт явуулж, зарчмын зөрүүтэй саналыг шийдвэрлэсэн болно.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Д.Сарангэрэл нараас анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн ээлжийн амралтын хугацааг ажлын 20 өдөр болгосныг ажлын 15 өдөр болгож буцаах, ажилласан жилээс нь хамааран нэмэгдэл амралтын өдрийг тооцдог байх зохицуулалтыг буцааж оруулах нь зүйтэй гэсэн санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь анхны хэлэлцүүлгээр дэмжиж, дахин санал хураах шаардлагатай гэж үзсэн бөгөөд төслийн 99 дүгээр зүйлийн 99.3 дахь хэсгийн ажлын 20 өдөр гэснийг ажлын 15 өдөр болон холбогдох бусад заалттай нийцүүлэх зарчмын зөрүүтэй саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналуудыг төсөлд нэмж тусган, төслийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг, хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж,

эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, Байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрөөтэй саналын томьёоллыг Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Хөдөлмөрийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны ерөнхий хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Дипломат албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж, хуулийн төслийг эцэслэн баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Т.Аюурсайхан:** Баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя.

Аюушийн Ариунзаяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Г.Өнөрбаяр яамны Төрийн нарийн бичгийн дарга, Б.Алимаа мөн яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Г.Адъяа Монголын Үйлдвэрчний Эвлэлийн холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга, Х.Ганбаатар Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбооны гүйцэтгэх захирал, О.Амартүвшин Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхимын Ерөнхийлөгч, Б.Уранцэцэг Удирдлагын академийн багш, доктор (PhD) профессор, Ж.Оюунчимэг Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхимын Бодлого, стратегийн газрын дарга, н.Батнасан хуульч гэсэн ажлын хэсгийг танилцуулж байна.

Ажлын хэсгийн бусад гишүүд цахимаар Ц.Отгонтунгалаг, Ш.Маяа нар Үйлдвэрчний эвлэлийн холбооноос, мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас оролцож байна.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байвал нэр өгье. Танхимд болон цахимаар нэрсийг тасаллаа.

Улсын Их Хурлын гишүүн Жамбалын Ганбаатар асуулт асууя.

**Ж.Ганбаатар:** Баярлалаа. Хөдөлмөрийн тухай хууль дээр зааланд цөөнх болж байгаагаа мэдэж байгаа. Нийгэм ч гэсэн одоохондоо ойлгох болоогүй байгааг

ч гэсэн харж байгаа. Нийгэмд сонсогдож байгаа хүмүүс бараг намайг өөрийгөө хамгаалаад ярьж байгаа байх гэж олонх нь бодож байгаа байх. Тэр бол яах вэ.

Зөрчлийн тухай хууль дээр ч гэсэн тухайн үед намайг бүр ойрын үдшийн цагаар олон хүн тойрч хуралдчихаад ч гэсэн доромжилж байсан зүйлүүд байгаа. Өнөөдөр Зөрчлийн тухай хууль дээр Өршөөлийн хууль батлах хэмжээнд хүрчихсэн байгаа шүү дээ. Өршөөлийн хууль батлах хэмжээнд хүрчихсэн байгаа.

Тэгэхээр тухайн үед над руу дайрч давшилж байсан хүмүүс өнөөдрийнхөө нөхцөл байдлыг ойлгож байгаа байлгүй дээ. Миний өөдөөс хараад сууж байгаа ч хүмүүс байгаа.

Яах вэ, Хөдөлмөрийн тухай хууль дээр би танхимд үнэхээр ойлгож байгаа. Дэмжлэг авахгүй гэдгээ мэдэж байгаа. Тэгэхдээ би яг хуулийн дагуу л явна. Ганцаар юу яалаа гээд нэг ширээ мэрийгээ нүдээд орилж харлаад байх юм байхгүй. Энэ чинь угаасаа хууль хэлэлцдэг зарчмаар нь л явна. Тэрийгээ мэддэг байх ёстой гэж ойлгож байгаа юм.

Тэгэхдээ энэ бол хүний ер нь хөдөлмөр эрхлэх сонирхол. Одоо саяын ингээд КОВИД-ын хууль гээд хар л даа. Тэгээд энэ КОВИД-д шаардагдаж байгаа хөрөнгө мөнгийг хэн гаргах юм.

Ер нь би хэлээд байгаа шүү дээ. Төсвийн алдагдлыг аж ахуйн нэгжүүд хаадаг байвал энэ зөв тогтолцоо. Яах вэ, томоохон хөрөнгө оруулалтууд руу бол зээл, тусламж орох ёстой. Энэ бол дэлхий нийтийн зарчим. Өнөөдөр бид төсвийн алдагдлаа зээл, тусламжаар хааж байгаа. Энэ чинь өөрөө өрнөөс өрний хооронд амьдарч байгаа юм.

Төсвийн алдагдлаа ядаж татварынхаа хэмжээгээр хаачихсан байж дараа нь Хөдөлмөрийн хуулиа ингэж ярих ёстой. Тэгэхдээ 70, 80 хувьд нь би дэмжиж байгаа гэдгээ илэрхийлж байгаа. Тэгээд бүгдийг нь дэмжихгүй байгаа юм шиг нийгэмд харагдуулаад л.

Нэг минутаар сунгаад.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Жамбалын Ганбаатар гишүүнд нэмэлт 1 минут.

**Ж.Ганбат:** Тэгээд л энэ Үйлдвэрчний эвлэлийн байгууллага, тэр нэг залуучуудаараа янз янзын юм бичүүлээд л. Тэгээд надад энэ байна л даа.

Тэгээд л нийгэмд капиталист, шулаач, мөлжөөчид. Юу юу ч гэнэ вэ. Хуульд чинь мэтгэлцэж оролцож болохгүй юу. Тэгээд л янз янзын хэл амаар доромжлоод л. Болих хэрэгтэй дээ. Асуудлыг зөв өнцгөөс нь харах хэрэгтэй.

Хоёроос гурван жилийн дараа нийгэмд ороод ирсний дараа та энд сууж байгаа олон хүмүүсээс би асууна. Яг хүмүүсийн амьдрал дээр тулаад ирэхлээр юу болох вэ. Ялангуяа хүнд үйлдвэрлэл шүү. Үйлдвэрлэлийн салбар. Хүнд хүчир ажил хийдэг хүмүүс. Ойлгохгүй хүмүүстэй бол би нэг их тэгж. Үүнийг чинь мэдрээгүй, дамжаагүй хүмүүст чинь хэлээд ойлгохгүй шүү дээ. Тэгээд хууль гараад батлагдаад,

тэр нь ингээд яг өөрт нь ингээд мэдрэгдээд нийгэмд мэдрэгдээд, өөрсдийг нь чимхээд ирэхлээрээ тэгээд Ж.Ганбаатар.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Ажил олгогч эздийн холбоо ер нь ямар байр суурьтай байгаа юм бэ? 88. Х.Ганбаатар Ерөнхийлөгч.

**Х.Ганбаатар:** Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амрыг эрье.

Тэгэхээр Хөдөлмөрийн тухай том хууль бол одоо ингээд батлагдах эцсийн шатандаа орж ирж байна. Одоо ажил олгогч эздийн байгууллага, бид энэ хуулийг батлуулъя гэсэн байр суурьтай байгаа. Ж.Ганбаатар гишүүний саналыг ч гэсэн бид ойлгож хүлээж авч байгаа. Энэ хүн бол бизнесийн хүрээнд учирч болох зарим нэг заалт, хүндрэлийн асуудлаар маш ажил хэрэг санал гарсан гэдгийг бид ойлгож байгаа.

Тийм учраас бид энэ хуулийн хүрээнд Үйлдвэрчний эвлэл, Засгийн газар, Худалдаа, аж үйлдвэрийн танхим, холбогдох байгууллагуудын зөвшилцсөн хувилбараар энэ хуулийг батлуулъя, баталж өгөөч ээ гэсэн ийм хүсэлт байгаа гэдгийг хэлье.

Ер нь энэ хуулийн 94, 95 хувийг нь ажил олгогчид дэмжиж байгаа. Санал нийлэхгүй асуудлууд байгаа. Үүнийг төр ингээд эрх мэдлийнхээ хүрээнд шийдэхэд бид дагаж биелүүлж, мөрдөж ажиллана гэдгээ хэлье. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Цахимаар Улсын Их Хурлын гишүүн Даваажанцангийн Сарангэрэл асуулт асууна.

**Д.Сарангэрэл:** Баярлалаа. Юуны өмнө Нийгмийн бодлогын байнгын хороо Хөдөлмөрийн хуулийн ажлын хэсгийн нөхдөдөө талархаж байгаа.

2 жил ажилласан, 20 жил ажилласан хүн ижилхэн хугацаатай амрахаар хуулийн төсөл явж байсныг нөгөө 5 жил тутамд 3 хоног амралтын өдөр нэмдэг. Энэ хуучин тогтолцоог нь хадгалж үлдэхээр ийм шийдэл Байнгын хороон дээр гаргасанд Та бүхэнд талархаж байгаагаа илэрхийлье.

Хоёрдугаарт, манай иргэд маань талархалтай хандах зүйл гэвэл яг энэ уул уурхайд ажилладаг, тухайлбал Оюу Толгой гэдэг юм уу, тэнд ажиллагсад маань 28 хоног ажиллаад, тэгээд дараа нь 10-аас 24 хоног амраад буцаад 28 хоног ажилдаа явдаг нь бол энэ гэр бүлийн асуудалд нэлээн хүндээр тусаж байсан. Үүнийг ямар ч байсан хугацааны хариуд наашлуулаад, 10-аас 14 хоног амрах боломжийг нь өгөөд. Тэгээд 28 биш 14 хоног ажилладаг болгох ийм амьдралд нийцсэн ийм уян хатан зохицуулалтуудыг хийж өгсөн байна лээ.

Тэгээд би ажлын хэсэгтээ, Байнгын хорооныхондоо энэ хуульд ажил хэрэгчээр хандсанд талархаж байна. Энэ бол олон Засгийн газар, олон парламентыг дамжиж ер нь ойлголцож өгөхгүй, шийдэл гарч чадахгүй байсан энэ асуудлуудыг дундын хувилбараар шийдэж өнөөдөр ингээд хуулийн төсөл маань эцсийн хэлэлцүүлэгтээ орж байгаад талархаж байна.

Миний асуух гэж байгаа гол зүйл юу вэ гэвэл ажлын байрны бэлгийн дарамтын асуудал дээр Улсын Их Хурал дахь 13 эмэгтэй гишүүн бол ажил хэрэгч хандаж байгаа.

Тэгэхээр энэ бид Хөдөлмөрийн хуулийн өөрчлөлт дээр их найдвар тавьж байгаа. Энэ дээр энэ Хөдөлмөрийн хуульд ажлын байрны бэлгийн дарамтын чиглэлээр ямар асуудал орсон бэ? Энэ асуудлууд орсноор дэвшил гаргах ийм боломж байгаа юу? Ажлын байрны нөгөө далд хэлбэрийн бэлгийн дарамт дээр ямар нэгэн нааштай, эмэгтэйчүүдэд эвтэйхэн байх, таатай байх, дарамтгүй ажиллах ийм боломж үүсгэхээр ямар заалт орсон бэ гэдгийг би бас ажлын хэсгээс нэгдүгээрт асууя.

Хоёрдугаарт, энэ хувийн бичиг баримт, хүний иргэний үнэмлэх, гадаад паспортыг барьцаалдаг. Хүнд итгэхгүй байгаа гэдэг юм уу, хүнд хүндэтгэлгүй хандаж байна гэдэг юм уу ийм асуудал.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Мөнхөөгийн Оюунчимэг хариулна.

**М.Оюунчимэг:** Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл Нийгмийн ардчилал Монголын эмэгтэйчүүдийн холбооны Ерөнхийлөгчийн хувиар маш чухал асуулт асууж байна.

Яг үнэнийг хэлэхэд манай Улсын Их Хурал дахь эмэгтэй гишүүд Хөдөлмөрийн тухай хуулийг хэлэлцэн батлах, энэ хуульд ажлын байран дахь бэлгийн дарамт, аливаа хүчирхийллийг үл тэвчих хандлага, уламжлалыг эвдэх заалтуудыг Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга дээр бүр маш тодорхой бүлэг, заалт болгож оруулж өгсөн байгаа.

Энэ дээр бүр жишээ нь ажлын байран дээр аливаа хэлбэрийн ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл бэлгийн дарамтыг хориглох, урьдчилан сэргийлэх, гомдлоо гаргах, яг шийдвэрлэх процессыг нь хүртэл маш тодорхой болгож өгсөн. Өмнө нь жишээлбэл хүн гомдол гаргахаасаа тухайн хүн ичээд, эсвэл бүр асуудалд ороод, тухайн ажлын байран дээрээ байж чадахгүй болтлоо болдог байсан бол одоо энэ хуулиар тэр ажлын байран дахь бэлгийн дарамт, хүчирхийлэл гэж яг юуг хэлэх юм гэдгийг ил байрлах. Үүнийг шийдвэрлүүлэх процесс, гомдлоо хаана гаргах юм, ямар байх вэ гэдгийг хүртэл олон нийтэд ил байхаар тавих ёстой гээд тухайн ажил олгогч, тэр хувийн хэвшлийн бүх хүмүүст нь яг үүнийг тодорхой хуулиар зааж өгөөд. Тэгээд та шийдвэрлэх процесс хэрвээ гомдол гаргасан тохиолдолд ингэж ингэж шийдвэрлэнэ. Та гомдлоо ийм ийм газруудад. Одоо Дээд шүүх, Хүний эрхийн Үндэсний Комисс, цагдаа, шүүх ийм ийм газруудад гаргаж болно. Шийдвэрлэх процесс ийм байна. Яг бэлгийн дарамт, хүчирхийлэл гэж, ажлын байран дахь дарамт гэж үүнийг хэлнэ гээд бүр томъёоллоор нь оруулаад өгсөн байгаа.

Тэгээд энэ удаагийн Хөдөлмөрийн хуулийн шинэчилсэн найруулгын нэг том зүйл нь энэ ажлын байран дахь бэлгийн дарамт, хүчирхийлэлтэй холбоотой асуудлууд байгаа юм.

Бид энэ Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Азийн хөгжлийн банк, Хүний эрхийн Үндэсний Комисс гээд олон газруудаас судалгаа хийж үзэхэд ажлын байран дахь бэлгийн дарамт манай Монгол Улсад, ялангуяа төрийн байгууллагууд дээр,

хувийн хэвшил дээр ч гэсэн хөдөө орон нутагт маш өндөр түвшинд гарсан. Тэгээд тухайн хүн нь хохироод үлддэг. Ажлаараа ч, амьдралаараа ч. Тэгвэл.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Одоо Салдангийн Одонтуяа гишүүн асуулт асууна.

**С.Одонтуяа:** Тэгэхээр ерөнхийдөө Хөдөлмөрийн хууль, ажлын хэсгийг ахалсан Ц.Мөнх-Оргил гишүүний хувьд 90 орчим хувь сэтгэл хангалуун байна.

Үнэхээр энэ маш том хууль. Бидний гишүүдээс гаргасан саналыг анхааралтай судалж авч дэмжиж өгсөн байгаа. Мэдээж бид амьдралд хэрэглэх явцад өөрчлөх асуудлууд бол гарна.

Нэг зүйл дээр жаахан сэтгэл дундуур үлдлээ. Энэ бол 31 дүгээр зүйл буюу ажлын бүтэн бус цагийн ажилтны хөдөлмөрийн гэрээ байгаа. Өөрөөр хэлбэл цагаар ажиллах хөдөлмөрийн хөлсний гэрээ. Өөрөөр хэлбэл Монгол Улсад өнөөдөр цагийн ажлын хөлсийг бид их тийм иргэдэд ээлтэй. Ялангуяа гэртээ хүүхдээ харж байгаа оюутнууд, ингээд давхар ажил хийдэг хүмүүс цагийн ажил хийх энэ эрмэлзлийг нь бий болговол бид өнөөдөр эдийн засгаа хөгжүүлж чадна.

Тэгэхээр энэ орсон заалт нь ямар нэгэн бүтэн цагаар ажиллаж байгаа хүмүүсээс нь ялгаагүй ийм заалт л орчихсон байна. Өөрөөр хэлбэл тэр нэг баахан татварууд нь бүгд л авахаар.

Тэгэхээр хэрвээ энэ цагаар ажиллаж байгаа хүмүүсийн тодорхой хэсэг дээр энэ татварыг нь бууруулдаг ч юм уу, эсвэл энэ ажилгүйдлийг бууруулна гэдэг талаас нь тодорхой ийм ач холбогдлууд өгсөн бол илүү энэ ажилтнуудаа цагийн ажлаар ажиллуулахын сэдэл нь нэлээн бий болох байсан юм уу гэж бодож байна. Яагаад гэхээр манай улсад чинь цагийн ажлын хөлс бол нэг тийм ойлгомжгүй. Ер нь энэ хэсгийн хөдөлмөрийн зах зээл бол их муу байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ 31 дүгээр зүйл дээр орсонгүй. Зүгээр л яг л ижил бүтэн цагаар ажиллаж байгаа хүмүүстэй ижил орчихсон нь өөрөө тийм нэг онцын ялгавар харагдахгүй байна.

Хоёрдугаарт, энэ бизнес эрхэлж байгаа хүмүүсийнхээ саналыг сайн тусгасан биз дээ. Надад ирж байгаа зарим захидал гомдлоор бол энэ.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Ц.Мөнх-Оргил. Цэндийн Мөнх-Оргил.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. С.Одонтуяа гишүүний асуулт, саналд хариулт, тайлбар өгье.

Цагаар ажиллах асуудал Хөдөлмөрийн хуульд тусгагдсан. Үүнээс илүү дэлгэрэнгүй С.Одонтуяа гишүүн ээ, цагаараа ажиллах асуудлыг Хөдөлмөрийн тухай хуульд дэлгэрэнгүй тусгаж болохгүй байгаа юм. Яагаад вэ.

Яагаад вэ гэхээр цагаар ажиллах нь өөрөө дотроо хоёр хуваагдах байхгүй юу. Хөдөлмөрийн гэрээтэй цагаар ажиллаж байгаа буюу одоо ажилтан болоод, тухайн байгууллагын ажилтан болоод цагаар ажиллах нэг тусдаа асуудал байна. Тэр

байгууллагын ажилтан болоогүй, тухайн үедээ дөнгөж ажлыг нь хийчхээд яваад өгөх асуудал тусдаа байгаа байхгүй юу.

Тэгэхээр үүнийг ингээд ажил хийж байгаа, цагаар ажиллаж байгаа хүн нь одоо яг ажилтан болоод ажиллаж байгаа бол бүтэн цагаар ажиллаж байгаа хүмүүстэйгээ адилхан эрх эдэлнэ шүү гэдэг зарчим нь чухал.

Таны хэлж байгаагаар өөр зарчимтай байх юм гээд тусгачих юм бол тэр нөгөө цагаар ажиллаж байгаа хүн чинь бусад хүмүүсээсээ дордчих байхгүй юу. Нөхцөл байдал нь. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, үүнийг зохицуулж байгаа эрх зүйн актууд байгаа. Энэ хууль батлагдаад хэрэгжээд явахаар Засгийн газраас авах арга хэмжээнүүд дотор ч байгаа. Өнөөдөр энэ асуудлыг Засгийн газрын тогтоолоор журамлаад явж байгаа юм. Үүнийг бид оюутнуудад л зориулж хэрэглэх ёстой байгаа юм. Оюутнуудад. Үүнээс цааш нь өргөжүүлээд явчих юм бол хүн болгоныг цагаар ажиллуулах гээд байдаг хандлага руу орчих аюултай байгаа байхгүй юу.

Тэгэхээр хүн чинь өөрөө сонирхоод цагаар ажиллах нэг өөр. Сонирхоогүй байхад нь чи заавал цагаар ажилла гээд шахаад байх нэг өөр нөхцөл үүсчих байхгүй юу.

Тэгэхээр энэ хоёр талын балансыг л барих тухай асуудал байгаа юм.

Бизнес эрхлэгчдийн саналыг олон удаа авсан. Сүүлийн 8 жил хэлэлцсэн. Ялангуяа манай ажлын хэсэг байгуулагдаад 3 жил хэлчихсэн. Олон удаагийн хэлэлцүүлэг хийгдсэн. Тэгээд миний хэлээд байгаа нэг санаа бол Үйлдвэрчний эвлэлийн санал.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Хариулт 1 минут.

**Ц.Мөнх-Оргил:** Тэгээд миний хэлээд байгаа нэг санаа бол энэ зөвшилцлийн баримт бичиг юм.

Зөвшилцлийн баримт бичиг учраас Үйлдвэрчний эвлэлийн санал бол жишээ нь 100 хувь тусгагдахгүй. Чадахгүй. Ажил олгогчдын санал 100 хувь тусгагдахгүй. Хууль тогтоогч та бидний санал ч гэсэн энэ дээр 100 хувь тусгагдаж чадахгүй.

Ингээд л тал талаасаа бид ойлголцоод Үйлдвэрчний эвлэл энэ асуудлууд бидэнд чухал байна гээд. Ажил олгогч энэ асуудал бидэнд чухал байна гээд өөр өөрсдийнхөө нөгөө асуудлын эрэмбэ дарааг л тогтоож бид үүндээ тэнцүүлж оруулж байгаа юм.

Тэгээд ажил олгогчдын санал туссан. Ажил олгогчдод одоо хуулиар шийдэгдэхгүй байгаа олон асуудлыг энэ хуулиар шийднэ. Хамгийн гол нь хуулиа сурталчлах, таниулах, байгууллагуудын хүний нөөцийн алба энэ хуулийг зөв хэрэглэх асуудал дээр л бид анхаарах ёстой гэж бодож байгаа юм. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн цахимаар.

**Ц.Даваасүрэн:** Баярлалаа. Энд хоёр зүйл асууя.

Нэгдүгээрт, биднийг энэ Оюу Толгой компани дээр ажиллахад манай монгол ажилчид нэг асуудлыг их тавьж байсан. Тэр 28 хоног ажиллаад 14 хоног амардаг ч билүү. Тэрийг 14, 14 болгоё гэдэг ийм асуудал их тавьсан. Энэ асуудал яаж шийдэгдсэн бэ гэж.

Хоёрдугаарт, тэр хариуцлага тооцох. Нөгөө халах, чөлөөлөх хуучин хөдөлмөрийн заалтуудад өөрчлөлт орсон уу гэсэн ийм хоёр зүйлийг асууя.

Ер нь хөдөлмөрийн харилцаа гэдэг бол хүний эрхийн асуудал байдаг.

Тийм учраас энэ хуулийг бид маш нарийн гаргах ёстой. Өмнөх, жишээлбэл хуулийн хэлэлцүүлэг дээр бид хүн хөдөлмөрлөх таатай нөхцөлөөр хангах, цалин авах, орлого олох асуудлыг КОВИД-ын хуулиар хязгаарлахаад байхад, Үндсэн хууль зөрчихөөд байхад Үндсэн хуулиа дагаж мөрдөнө гэсэн Улсын Их Хурлын гишүүд нь зүгээр л дуугүй өнгөрчхөж байна шүү дээ. Өөр яах юм гээд өнгөрчхөж байна шүү дээ.

Хүн үхэж байна гээд тэгэхээр гурав үхэх байсан юм, нэг үхүүлээ гээд ингээд сууж байна шүү дээ. Ийм хариуцлагагүй Их Хурал бий болчихсон байна шүү дээ.

Тэгээд ер нь энэ мэдлэг чадвар нь дутаад байна уу, аль эсвэл нийтлэг эрх ашгийг үл хүндэтгэх улсууд энэ Их Хурлаар дүүрчхэв үү? Би өнөөдөр үнэхээр эмзэглэж байна. Би дөрвөн Их Хуралд суусан. Өмнөх Их Хурлуудад хуулийн зөрчлийн асуудал дээр маш хариуцлагатай ханддаг байсан. Хуулийн төслийг буцаадаг байсан. Зөрчилтэй хууль баталдаггүй байсан. Одоогийн энэ гишүүд Үндсэн хууль битгий хэл, ер нь энэ хуулийн зөрчлийн асуудлуудыг ерөөсөө тоохоо больчихсон.

Тэгэхээр ийм хүмүүс энэ Хөдөлмөрийн хуулийг сайн гаргаж чадах уу гэдэгт би эргэлзэж байна л даа. Хөдөлмөрийн харилцаа гэдэг бол хүний эрхийн асуудал. Хүний хамгийн гол зүйл бол хөдөлмөрлөх, амьд явах асуудал. Тийм биз. Гэтэл өнөөдөр ийм хариуцлагагүй, Үндсэн хуулиа үл тоодог ийм хүмүүс сайн Хөдөлмөрийн хууль гаргаж чадах уу. Би энд үнэхээр эргэлзэж байна.

Үндсэн хуулийг бид ягштал мөрддөг байх ёстой шүү дээ. Үндсэн хуулиа хөндөхгүйгээр юмыг зохицуулж чаддаг байх ёстой.

**Г.Занданшатар:** Цэндийн Мөнх-Оргил гишүүн.

**Ц.Мөнх-Оргил:** Ц.Даваасүрэн гишүүний асуусан хоёр асуултад хариулъя.

Нэгдүгээр асуулт. Уртын ээлж буюу одоо нөгөө салбарт нь нөгөө ротацаар ажиллах гэж нэрлээд байгаа юм л даа. Тэгээд энэ өргөн барихдаа бол жасаагаараа гэсэн нэр томьёотой орж ирснийг ажлын хэсэг дээр бид ярьж байгаад, Байнгын хороон дээр ярьж байгаад уртын ээлж болгож нэр томьёог нь өөрчилсөн.

Засгийн газар өргөн барихдаа 21 хоногоос илүүгүй ажиллана. Өөрөөр хэлбэл хамгийн урт хугацаа нь бол 21. 10-аас доошгүй өдөр амарна. Тэгээд энэ яг тодорхой хугацаагаа хоорондоо тохироо гэсэн зохицуулалт орж ирсэн.

Уул уурхайн салбарын Үйлдвэрчний эвлэлийн санал, уурхайчдаас олон санал ирсний дотор энэ 14, 14-өөр тогтоож өгөөч ээ гэсэн хүсэлт ирсэн. Үүнийг бид хүлээж аваад 14, 14 болгосон. Одоо ингээд хуульдаа 14, 14-өөр батлагдана.

Энэ дээр нэмэлт санал ирсэн. Ялангуяа орон нутгийн жижиг уурхайнуудаас бид 14, 14-өөр ажиллуулдаггүй юм. Бид ихэнхдээ долоо, долоо хоногоор ажиллуулдаг юм.

Тийм учраас энэ дотор нь 14-өөс илүүгүй ажиллуулах зохицуулалт нь дотроо 14-өөс цөөхөн хоног ажиллах юм бол тэр ажилласан өдөртэйгөө тэнцэж амрах бололцоог олгож өгөөч ээ гэсэн хүсэлт ирсэн. Тэгээд үүнийг нь бид сая ажлын хэсэг дээрээ, Байнгын хороон дээрээ яриад хүлээж аваад 14 хоног ажиллана. 14 хоног амарна. Үүнээс цөөхөн өдөр ажиллах юм бол ажилласан өдөртэйгөө тэнцсэн хоногоор амарна шүү. Үүнийг хоорондоо ажил олгогч, ажилчдын төлөөлөгч хоорондоо тохироо гэдэг арай жаахан уян хатан болгосон зохицуулалт оруулсан.

Тэр ажлаас чөлөөлөх, өөрийнхөө хүсэлтээр болон ажил олгогчийн санаачилгаар чөлөөлөгдөх асуудлууд бол нэлээн дэлгэрэнгүй туссан. Дэлгэрэнгүй туссан. Энэ дотор хамгийн гол нь ажил олгогчийн үүрэг, эрх, ажилтны үүрэг, эрх гэдэг заалтуудыг нэлээн дэлгэрүүлж өгсөн. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн.

**Х.Булгантуяа:** Энэ хөдөлмөрийн асуудлаар Монгол Ардын намын мөрийн хөтөлбөр, тэгээд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт хоёр зүйл, заалт орсон байдаг. 1.2.9 дээр хөдөлмөрийн зах зээлийг орчин үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинэчилж, ажлын үнэлгээг цагаар тооцох. Ур чадвар, үр дүнд суурилсан цалин хөлсний систем бүрдүүлнэ гэсэн. Цагаар тооцох асуудал бол 31 дээр орсон байна.

Энэ ур чадвар, үр дүнд суурилсан цалин хөлсний систем гэдэг дээр яг ямархуу шинэчлэлт, ахиц дэвшил гарсан бэ?

1.2.10 дээр хүн бүрийг хөдөлмөрийн цахим бүртгэлтэй болгож, нийгмийн даатгал, хамгааллын тогтолцоог уялдуулсан хөдөлмөр эрхлэх хариуцлагыг нэмэгдүүлнэ гэсэн байж байгаа.

Тэгэхээр үүн дээр энэ цахим бүртгэлтэй холбоотой ямар зүйл, заалт орсон бэ?

Азийн хөгжлийн банкнаас Монгол Улсын хөдөлмөрийн зах зээл дээр, ялангуяа энэ жендэрийн тэгш байдлыг хангах талаар хийсэн судалгаа байдаг. Үүн дээр ялангуяа энэ 45 ба түүнээс дээш насныханд шаардлагатай мэргэшүүлэх сургалтыг хийх хэрэгтэй байна. Ялангуяа одоо ээж нар олон жил хүүхэд гаргаад декреттэй сууж байгаад буцаад ажилд орох гэхээр ажлын байр энэ дээр ээлгүй

байна. Маш их ээлгүй байна. Үүн дээр ямар нэгэн зүйл, заалт орсон уу гэдэг нэг ийм хэдэн асуултуудыг асуух гэсэн юм.

Энэ удаагийн хууль дээр, ялангуяа энэ ажлын байрны бэлгийн дарамт гэх мэтчилэн тодорхой ахиц дэвшлүүд бол маш сайн гарсан. Үүнийг хэлүүштэй.

Түрүүн нэг асуулт дээр ялангуяа энэ хөдөлмөр эрхлэгчдээс өмнөх Хөдөлмөрийн хууль маань ерөнхийдөө ажилтан талдаа илүү их байсан. Үүнийг улам их лавшруулсан ийм хууль батлагдаж байгаа юм биш үү. КОВИД-ын дараагаар бизнес эрхлэгчид бүгдээрээ хүнд байхаар байна.

Ер нь ихэнхдээ дандаа ажил олгогч, хууль шүүхийн байгууллага дээр очоод дандаа алддаг. Дандаа торгууль төлж таардаг. Дандаа нөхөн олговор өгч таардаг. Энэ чинь бүр их хүндрээд ороод ирж байгаа юм биш үү гэсэн ийм асуултыг их тавьж байна лээ. Үүн дээр манай ажлын хэсэг, холбогдох яам Тамгын газар нь өөрсдөө сайн мэдэж байгаа байх. Худалдаа, аж үйлдвэрийн.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Цэндийн Мөнх-Оргил. Ажлын хэсгийн ахлагч.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Энэ цалин хөлс олголттой холбоотой Долоодугаар бүлэгт бид энэ цалин хөлсийг олгоход ямар зарчим баримтлах вэ гэдгийг нэлээн тодорхой, дэлгэрэнгүй тусгаж өгсөн.

Энэ гол зарчим бол одоо бидний баталж байгаа хуулийн 102.1.1-д ижил үнэлэмжтэй ажил, үүрэг гүйцэтгэж байгаа ажилтны цалин хөлсний хэмжээ адил байх зарчмыг тусгасан. Ижил үнэлэмжтэй.

Одоо хүчин төгөлдөр байгаа, үйлчилж байгаа хуульд ерөнхий санаа нь юу гэхээр ижил төрлийн ажил хийж байгаа хүмүүстэй адилхан цалин олгоно гээд байгаа байхгүй юу. Тийм ээ. Ижил, адилхан ажил хийж байгаа эрэгтэй эмэгтэй хүн хоёрт адилхан цалин олгоно гээд.

Тэгэхээр бид эрэгтэй эмэгтэй нь хамаагүй. Яг адилхан ажил хийж байна уу, үгүй юу гэдэг нь бас хамаагүй. Ажил чинь ижил үнэлэмжтэй байх ёстой гэж үнэлэмжийн асуудал ярьж байгаа юм.

Тэгээд энэ дээр сүүлийн дөрөв, таван жилийн хугацаанд С.Чинзориг сайдаас эхлээд одоо А.Ариунзаяа сайдын үргэлжлүүлж байгаа нэг чухал ажил бол энэ ажлын үнэлэмжийг гаргаж байгаа юм. Жишээ нь, хоёр жилийн өмнөөс эхлээд сувилагч нар янз янзын цалин авдаг болсон. Жишээ нь, мэс заслын тасгийн сувилагч, дотрын тасгийн сувилагчаас хамаагүй өндөр цалин авна. Тийм ээ. Яагаад гэвэл ажил нь хэцүү.

Бага сургуулийн болон цэцэрлэгийн багш нар, дунд сургуулийн багш нараас өндөр цалин авна. Яагаад вэ. Яагаад гэвэл үнэлэмжийн өөр. Ажил нь хэцүү гээд. Тэгээд энэ зарчмаар цаашаа явна.

Тэгээд үүнийг хэрэгжүүлэхэд маш их техник ажил шаардагдана. Өөрөөр хэлбэл ажил болгоны үнэлэмжийг тогтоох асуудал гарч байгаа юм. Тэгээд салбар салбараар нь хийж байгаа. Одоо боловсролын салбар, эрүүл мэндийн салбар хоёрт

хийчихсэн. Дараа дараагийн салбаруудынхаа ажлыг үнэлэмжийг гаргах асуудлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хийж байгаа.

Тэр хүн бүрийн цахим бүртгэлтэй холбоотой асуудлыг А.Ариунзаяа сайд тайлбарлаад өгчих үү? Энэ гол нь нөгөө нийгмийн даатгалтай холбоотой асуудал байгаа юм. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой.

**Г.Занданшатар:** А.Ариунзаяа сайд 81. Аюушийн Ариунзаяа сайд.

**А.Ариунзаяа:** Х.Булгантуяа гишүүний асуултад хариулъя.

Хуулийн төслийн 102 дээр ур чадвар, үнэлэмж дээр нь суурилсан цалин хөлсний зарчим баримтална гэдэг нь орсон байгаа.

Цахим бүртгэлийн тухайд 83.8 дээр тусгайлсан нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна гэдэг заалт нь орсон байгаа.

Одоогоор ч гэсэн энэ бүртгэл нь байдаг байгаа. Хүн бүхэн нийгмийн даатгалын аппликэйшнийг жишээлбэл гар утсан дээрээ суулгахад таны бүх бүртгэл, бүх ажиллаж байсан хугацааны, нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, нэрийн дансны үлдэгдэл гэх мэтчилэн бүхий л асуудлууд байдаг.

Бид энэ системээ цаашаага улам төгөлдөржүүлж, тухайн хүний нөөцийн байгууллагуудаас ирдэг нэг асуудал нь бол тухайн ажилтны ажлын байрны тодорхойлолтыг энэ системдээ суулгаж өгөөч ээ гэсэн асуудлыг дэвшүүлдэг байгаа. Тэгээд бид системдээ буюу хуульдаа ямар ч байсан ажил олгогч хүсэх юм бол өмнөх ажил олгогчоос нь тодорхойлолт авч болно гэдэг заалтыг бол оруулсан байгаа.

Тэгээд үүнийг системийн хэмжээнд бид цаашдаа төгөлдөржүүлээд, Нийгмийн даатгалын багц хуульдаа бас тусгайлаад бүртгэлийн талаар асуудлуудыг тусгайлж оруулсан байгаа. Төд удалгүй бид Засгийн газартаа Нийгмийн даатгалын багц хуулиа өргөн мэдүүлчихсэн байна. Удахгүй хэлэлцээд явна гэдгийг хэлье. Баярлалаа.

**Г.Занданшатар:** 45-аас дээш насны. А.Ариунзаяа сайд гүйцээгээд хариулчих.

**А.Ариунзаяа:** 45-аас дээш насны хүмүүсийн сургалтын асуудлыг бид хуульд тусгайлж заагаагүй байгаа.

Гэхдээ мэдээж бид Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хуулиар тусгайлж энэ асуудлыг оруулах ёстой. Хөдөлмөрийн хууль нь бол хөдөлмөрийн харилцааг зохицуулж байгаа хууль учраас тусгайлсан ийм зохицуулалтуудыг төдийлөн оруулаагүй.

Хөдөлмөрийн дотоод журам болон Ажил олгогч эздийн холбоо, Үйлдвэрчний эвлэлтэй бид тусгайлсан хөтөлбөрүүдийг зохион байгуулж байгаа. Үүнд шинээр ажилд орсон, хүүхэд гаргаад эргээд ажилдаа орсон, шинэ техник, технологийн дэвшилттэй холбоотой сургалтуудыг заавал ч үгүй явуулах ёстой гэдгийг оруулсан байгаа.

Агуулгаараа Хөдөлмөрийн хуульд юу орсон бэ гэхээр шинэ техник, технологи дэвшүүлэх юм бол ажил олгогч заавал ч үгүй тухайн хүнийг ажлын байр дээр нь сургана гэдэг зохицуулалтуудыг оруулсан. Хэрэв тухайн хүн ур чадвараараа тэнцэхгүй гэх юм бол заавал ч үгүй ажилтныг сургасан байж дараад нь ур чадвар нь тэнцэхгүй байна гэдэг асуудлыг ярина гэдэг зохицуулалтыг Хөдөлмөрийн хуульд тусгайлж оруулж өгсөн байгаа.

**Г.Занданшатар:** Х.Булгантуяа гишүүн болсон уу? Тийм ээ. Одоо Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн.

**Ж.Сүхбаатар:** Би үг хэлэхээсээ өмнө нэг зүйлийг хэлье гэж бодож байна.

Түрүүн С.Амарсайхан дарга нөгөө КОВИД-ын эсрэг хуулийн асуудал дээр 6 хүний үг авчихлаа гээд ингээд хаачихсан. Дэмжсэн гурваа хэлүүлэх ёстой байсан байхгүй юу. Тэгэхэд дэмжиж байгаа 5-ыг хэлүүлчхээд тэгээд дэмжихгүй байгаа 1 хүн хэлүүлчхээд тэгээд 6 хүн болсон гээд.

Ингээд цаашдаа энэ юмаа анхаармаар юм. Дэмжихгүй байгаа 3 хүнээ хэлүүлж баймаар байна шүү дээ. Тоо нь 6 болчихсон гээд худлаа ингээд орхигдуулсан маягийн юм ингээд яриад явчхаж байгаа байхгүй юу.

Тэгээд наадхаа анхаараарай. Нэгдүгээрх асуудал.

Хоёрдугаарт, энэ хууль дээр би их онцолж байгаа юм бол Хүний эрхийн Үндэсний Комиссын 19, 20 дугаар илтгэлийн санаанууд орсон юм байна гэж харсан. Ялангуяа “**туслах малчин**”, “**гэр үйлчилгээний ажилтан**”-ы асуудал энд орж ирж байна.

Энэ бол үнэхээр сүүлийн олон жилийн хугацаанд Монголд бий болсон олон мянган үйлчилгээний ажлын байрны зах зээл бол мөн. “Туслах малчин”, “гэрийн үйлчилгээний ажилтан”. Одоо бүр нарийн туслах малчны цалин хөлсийг 30-аас илүүгүй хувийг мөнгөн бус хэлбэрээр олгож болно гээд. Яг ингээд харах юм бол маш нарийн заасан байна лээ.

Ер нь хууль бол зүгээр өмнөх олон харилцаанууд, зохицуулалтгүй асуудлуудыг зохицуулах гэж, нарийвчлах гэж оролдсон. Зүгээр яг биелэлт, хэрэгжилт яах вэ гэдэг асуудал байгаа юм. Би энэ утгаар нь асуух гэж байгаа юм.

Жишээлбэл, гэр бүлийн хүчирхийллийн асуудал бид их ярьдаг. Эрүүгийн хууль дээрээ харах юм бол нөгөө нөхөр нь бараг жилээс илүү хоригдохгүй. Тийм л нэг хөнгөн ялтай. Бид аягүй их ярьдаг. Тэгээд хуулийн цаана дандаа тэр хариуцлага байх ёстой шүү дээ.

Тэгэхээр энэ ажлын байран дахь бэлгийн дарамтын асуудал гэдэг чинь эрүүгийн хариуцлага дээрээ яаж тусах юм бэ? Ийм дарамт үзүүлдэг улсуудыг бид хоёр, гурван жил хорихоос нааш энэ чинь бүтэхгүй. Энэ асуудал яаж анхаарсан бэ?

Гурав дахь юм нь, энд Үйлдвэрчний эвлэл гээд нэг том тал байж байгаа. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хуулиар л зохицуулж байгаа шүү дээ. 30 гаруй жил өөрчлөгдөөгүй. Өөрчилдөггүй. Энэ Хөдөлмөрийн хуулийг хэлэлцэх явцад

Үйлдвэрчний эвлэлийн хуулийг өөрчлөх асуудал яригдсан уу? Энд чинь Үйлдвэрчний эвлэл нэлээн эрхтэй, үүрэгтэй оролцохоор энэ хуульд орчихсон байгаа.

**Г.Занданшатар:** Цэндийн Мөнх-Оргил гишүүн.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Хөдөлмөрийн хуулийн шинэчилсэн найруулгатай хамт Засгийн газраас Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, ялангуяа энэ бэлгийн дарамт учруулагчид, бэлгийн дарамттай тэмцэх асуудлаар хүлээсэн хариуцлага, үүргээ биелүүлэхгүй байгаа нөхдөд хариуцлага тооцох гээд нэлээн олон заалттай Зөрчлийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтүүд орж ирсэн.

Ажлын хэсэг дээр ярьж байгаад бид энэ зөвхөн зөрчлийн тухай асуудал биш юм. Энэ өөрөө эрүүгийн гэмт хэргийн шинжтэй юм. Тийм учраас эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ёстой юм гээд саналууд бэлтгэсэн. Бэлтгээд Хууль зүйн байнгын хороонд танилцуулсан. Хууль зүйн байнгын хороон дээр танилцуулаад яригдаж байх явцад Засгийн газраас, мөн Их Хурлын Тамгын газраас ажлын хэсэгт, Нийгмийн бодлогын байнгын хороонд ямар санал ирүүлсэн бэ гэхээр намрын чуулганаар Засгийн газраас Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга орж ирэх гэж байгаа юм байна. Мөн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал орж ирж байгаа юм байна.

Тийм учраас Хөдөлмөрийн хууль 2022 оны 01 сарын 01-нээс өмнө нэгэнт хүчин төгөлдөр болох учраас тэр хугацаанд Засгийн газрыг энэ батлагдсан Хөдөлмөрийн хуультайгаа нийцүүлээд Зөрчлийн хууль, Эрүүгийн хуульдаа хариуцлага тооцсон асуудлыг оруулаад ирье. Илүү зохимжтой биш үү гэсэн санал тавьсан.

Тэгээд тэр саналыг нь хүлээж аваад энэ Хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль болон энэ хуулийн хэрэгжилтийг хангах Улсын Их Хурлын тогтоолд одоо бид батлах ёстой тогтоолын төсөлд Засгийн газарт намрын чуулганаар Хөдөлмөрийн хууль батлагдсантай холбогдуулж эрүү, иргэн, зөрчлийн хуульд оруулсан нэмэлтүүдээ өргөн барь гэдэг үүрэг өгч байгаа юм.

Мөн Таны хоёр дахь асуултад хариулахад. Үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагааг зохицуулж байгаа хууль тогтоомжийг шинэчлэх асуудал олон удаа яригдсан. Тэгээд энэ батлах гэж байгаа тогтоолд Үйлдвэрчний эвлэлийн хуулийг шинэчлэн найруулж оруулж ирэхийг Засгийн газарт 2022 онд.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Ж.Сүхбаатар гишүүн тодруулна. 1 минут.

**Ж.Сүхбаатар:** Ингээд Хөдөлмөрийн хууль гарах нь. Одоо эцсийн хэлэлцүүлгийг нь бид хийх гэж байна.

Хөдөлмөрийн хууль маань гарахаар зэрэг манай хөдөлмөрийн эрх зүйн хөгжил бол шинэ шатанд гарна гэж би харж байгаа. Одоо бас нэлээн олон жил ингээд өөрчлөгдсөнгүй. Үүний араас би түрүүн хариуцлагын системийг ингээд араас нь намар ярих юм байна.

Эндээс гадна энэ Хөдөлмөрийн хуулийг эрхлэхэд ер нь **“хөдөлмөрийн шүүх”**-ийн асуудал гэдэг шиг энэ **“дагнасан шүүгч”** нарыг бэлтгэх гэдэг юм уу.

Үүнийг чинь одоо бас шүүгч нарыгаа дадлагажуулах, мэргэшүүлэх асуудал тавигдана шүү дээ.

Тэгэхээр энэ хүрээнд энэ хуулийг гаргахад тогтоол гэдэг юм уу, энэ асуудлаар юу гэж харж тооцсон бэ? Бид цаашдаа энэ **“гэр бүлийн шүүх”**-ийг би байгуулах ёстой гэдэг асуудал тавина гэж бодож байгаа. Их Хурлын даргад энэ дашрамд хэлье. Монголд зайлшгүй **“гэр бүлийн шүүх”** байгуулах ёстой юм билээ.

Хөдөлмөрийн маргааны асуудал шинэ шатанд гарч байгаа учраас энэ шүүгч нарын асуудал, давтан сургах, бэлтгэх, дагнуулах. Цаашилбал **“хөдөлмөрийн шүүх”**-ийн асуудал ч гэдэг юм уу. Энэ чиглэлийн асуудал дээр бодож төлөвлөсөн юм юу бодож ярилцсан бол гэдэг. Үүнийг бас тодруулаад энэ завшааныг ашиглаад асуучихъя гэж бодож байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Цэндийн Мөнх-Оргил гишүүн.

**Ц.Мөнх-Оргил:** Ж.Сүхбаатар гишүүний асуултад тодотгож хариулахад.

Түрүүн би санаагаа дуусгаж чадсангүй. Микрофон унтарчихлаа. Үйлдвэрчний эвлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2022 онд багтааж оруулж ир гэсэн үүрэг даалгаврыг бид энэ тогтоолоор Улсын Их Хурал, Засгийн газарт үүрэг болгож байгаа.

Шүүхтэй холбоотой асуудал дээр энэ хуулийн төслийг боловсруулахад манай Шүүхийн судалгааны төвийнхөн, мөн Дээд шүүхийн дэргэд байгаа Эвлэрүүлэн зуучлах төвийн ажилтнууд, тухайлбал Д.Тунгалаг шүүгч бидний ажилд их тус дэмжлэг болж орсон.

Тэгээд хууль батлагдмагц бид том хэмжээний сургалт, сурталчилгаа, танин мэдүүлэх том ажлуудыг зохион байгуулах ёстой. Энэ үүрэг, даалгаврыг мөн Засгийн газарт өгч байгаа. Энэ дотор шүүгч нарыг бэлтгэх асуудал. Мөн **“хөдөлмөрийн арбитрч”, “хөдөлмөрийн эвлэрүүлэн зуучлагч”** нарыг бэлтгэх асуудалд Худалдаа аж үйлдвэрийн танхим, Ажил олгогчдын холбоо, Үйлдвэрчний эвлэл Засгийн газартай хамтарч ажиллаж энэ сургалт, сурталчилгааны ажлуудыг хийхэд оролцоно. Энэ том сурталчилгааны ажил болно.

Тэгээд энэ дээр та бидний сая баталсан Шүүхийн тухай хуулийн Дээд шүүхийн дэргэд байгуулагдсан Сургалт, судалгааны төв дээр суурилж шүүгч нарын дунд хийх сурталчилгаа, судалгааны ажлыг эрчимжүүлнэ гэсэн бодолтой байгаа. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

**М.Оюунчимэг:** Би ажлын хэсгийн гишүүн, Нийгмийн бодлогын байнгын хорооны даргын хувьд нэг зүйлийг санал хураалт явуулахаас өмнө хэлмээр санагдаад байна л даа.

Түрүүн Ц.Даваасүрэн гишүүн хэлээд байна. Хөдөлмөрийн харилцаа гэдэг бол хүний эрхийн асуудал гээд. Тэд энэ Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн

найруулга бол Үндсэн хуулийн дараа орох маш том ийм хууль эрх зүйн акт. Тэгээд бид хөдөлмөрийн зах зээл дээр бол Үндсэн хууль гэсэн үг.

Тэгэхээр энэ дээр жишээ нь манай ганц нэг ажил олгогч, бизнесмен гишүүд маань тэр Бүгд Найрамдах Монгол Ард Улсын саяын нөгөө Ж.Сүхбаатар гишүүний хэлдэг шиг тэр 30 жилийн өмнөх хуулиараа л явъя даа гээд байгааг жаахан ойлгохгүй байгаад байгаа юм.

Яг үнэнийг хэлэхэд түрүүн жишээлбэл Ж.Ганбаатар гишүүн энэ 11 саналыг л та нарт тусгаад өгвөл бүх юм болчих гээд байна гэсэн. Бид 6.3.2-оор сая эцсийн хэлэлцүүлэг дээр тусгаад 4 нь хэдийн уншаад тусгагдаад явсан санал. Харин нэг нь суурь зарчим. Монгол Улсын Хөдөлмөрийн хуулийн суурь зарчим хүний эрхийн асуудалтай зөрчилдөж байгаа учраас нэгийг нь хүлээж авах боломжгүй байна гээд санал өгчихсөн.

Тэгэхээр энэ дээр бас ингээд иргэдэд буруу зөрүү ойлголт битгий өгөөсэй гэж би бодож байгаа юм.

Ер нь тэгээд баялаг бүтээж байгаа хүний баялаг нь өөрөө хүний нөөц шүү дээ. Өнөөдөр бид эрүүл мэндийн салбар хүний нөөцгүй болчихлоо гээд байна. Дарга нар бол зөндөө байна. Томилогдоод л тушаалаар очоод байна. Гэтэл хүний нөөц гэдэг ямар үнэ цэнтэй гэдгийг өнөөдөр манай энтрепренёр компаниудын хүний нөөцөө маш өндөрт тавьж байна шүү дээ. Одоо энэ Ж.Батсайхан захирал, Ж.Оджаргал захирал, манай О.Амартүвшин Ерөнхийлөгч хэлэх байх. Тийм ээ. Тэнд хүмүүс хөгжөөд, дэвшээд, дахиад шинэ энтрепренёр болоод явж байна.

Тэгэхээр хөдөлмөрийн харилцаа гэдэг бол яг л энэ хүний эрхийн харилцаа. Тэгээд энэ Хөдөлмөрийн тухай хуульд бид ажил олгогчдынхоо саналыг харин өмнөх Хөдөлмөрийн хуулиас хамаагүй илүү их тусгаж энэ хөдөлмөрийн зах зээлд энэ нь илүү орж ирж байгаа юм.

Тэр Х.Ганбаатар дарга Ажил олгогч эздийн нэгдсэн холбооны дарга маань хэлсэн шүү дээ. Энэ хуулийн онцлог бол ажил олгогчдод тулгарч байгаа өнөөдрийн асуудлын шийдлийг харин сайн тусгаж өгсөн гээд.

Тэгэхээр бид энэ хууль маань аль аль талын, хүний эрхийн талаасаа ч, хөдөлмөр эрхэлж байгаа хүн талаасаа ч, ажил олгож байгаа хүн талаасаа ч энэ харилцааг бол маш сайн боломжийн хэмжээнд тусгасан. Бас 30 жилийн туршид.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Санал хэлэхгүй. Одоо нөгөө эцсийн хэлэлцүүлэг шүү дээ. Одоо Одонгийн Цогтгэрэл гишүүн. Тэгээд санал хураалт явна шүү.

**О.Цогтгэрэл:** Баярлалаа. Энэ Хөдөлмөрийн хууль бол маш чухал хууль. Энэ хүний хөдөлмөрлөх эрх, олон зүйлтэй холбоотой нь мэдэж.

Тэгэхээр энэ хууль дээр төгсгөлд нь хууль эцсийн хэлэлцүүлэгт явж байгаа юм чинь. Яг энэ хуулийн үр дүнд хууль чинь **“ажилтан”**, **“ажил олгогч”** гэдэг хоёр хүний яг эрх ашгийн огтлолцлын цэг чинь өөрөө **“ажлын байр”** гэдэг ойлголт дээр

очиж байдаг. “Ажлын байр” чинь өөрөө үнэхээр “бүтээмжтэй” байх гээд. Энэ гурван асуудлын “ажилтны эрх ашиг”, “ажил олгогчийн эрх ашиг”, “бүтээмж”.

Тэгэхээр эндээс энэ хууль маань өөрөө тэгвэл тэгнэ, ингэвэл ингэнэ гэж захиргааны олон шийдлүүд хөдөлмөрийн маргаанаасаа гадна яг органикаараа чанартай ажлын байр гэдэг ойлголт эндээс гарч ирэх боломж бүрдэж байна уу? Би тийм юм олж харахгүй л байна л даа. Юу хэлэх гээд байна вэ гэвэл үнэхээр нэг эталон болсон хэмжүүр болсон, энэ ажлын байрны хувьд чанартай ажлын байр гэдэг зүйл гараад ирчихсэн ажилтан нь сэтгэл хангалуун, ажил олгогч сэтгэл хангалуун орлого, байгууллагын өрсөлдөх чадвар өндөр. Ийм гурвын огтлолцол дээр очвол нөгөө нэг бид нарын хуулиар зохицуулах гээд байгаа маш олон хөдөлмөрийн маргаан чинь алга болох ёстой байх гэж.

Тийм учраас энэ Хөдөлмөрийн хууль дээр тэр эталон маягийн бүтээмжээсээ цалин, эрүүл, аюулгүй ажлын орчин талаасаа хамаарсан ийм ажлын байруудыг тийм чанартай ажлын байр гэдэг шалгуурыг төрийн захиргааны төв байгууллагаас ч юм уу ингэж зарладаг тийм схем байвал ямар вэ?

Жишээ нь, энэ ажлын байрыг ийм цалин өгөөд ингээд ингээд явбал дэлхийн дунджаар ийм байвал. Дэлхийн дундаж ч юу байх вэ дээ. Тэндээс ингээд бүтээмж харахад ийм гэхивэл энэ Хөдөлмөрийн хууль маань шүүхээр очиж шийдэгдэхгүй. Хөдөлмөрийн маргаанууд. Маш олон маргаан ерөөсөө л бид ажлын байран дээрээ тал талдаа сэтгэл хангалуун байгаад харилцан энэ хуулийн хүрээнд ажиллах боломж бололцоо бүрдэх юм.

Тэгэхээр яг энд чанартай ажлын байр гэдэг ойлголтыг энд яг яаж томьёолж харж болох вэ? Ажлын байр чанартай байх. Ажлын байр стандарт байх. Энэ тухай нэг тодруулга өгөөч.

**Г.Занданшатар:** Цэндийн Мөнх-Оргил гишүүн. Ажлын хэсгийн ахлагч.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. О.Цогтгэрэл гишүүний асуултад товч хариулахыг бодъё.

О.Цогтгэрэл гишүүн ээ, би санааг чинь ойлголоо. Тэгэхдээ энэ хуульд бид чанартай ажлын байр гэж ийм юм байна гэдэг ерөнхий л зохицуулалтууд оруулж өгнө л дөө. Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангасан, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй цалин олгоно, дарамтлахгүй, ялгаварлан гадуурхахгүй, ижил үнэлэмжтэй ажилд ижил цалин өгнө гэж. Ингэж л ерөнхий суурь зарчмыг л тогтооно.

Яагаад гэвэл нөгөө ажлын байр чинь хэдэн олон арван мянгаараа л янз янз л байгаа шүү дээ. Тийм ээ. Яг нэг багш гэхэд л цэцэрлэгийн багш, сургуулийн багш, их сургуулийн багш гэдэг ч юм уу. Ингээд маш олон мянган төрлийн ажлын байртай учраас үүнийг хуулиараа бид эталон гаргаж өгөх бололцоогүй.

Ерөнхий санаа нь бол яг таны саяын хэлж байгаа тэр санаанд энэ хууль бүхэлдээ чиглэгдэж байгаа юм. Өөрөөр хэлбэл энэ ажилтан, ажил олгогч хоёр бол бие биеийгээ нэг дайсагнаж харсан эсрэг тал биш шүү. Нэг юмны төлөө явж байгаа, нэг ажлын төлөө явж байгаа багш шүү. Багш болж ажиллах ёстой юм шүү гэдэг энэ санааг их гүнзгий тусгаж өгөх гэж оролдсон юм.

Тэгээд хэрэгжилт нь одоо амьдрал дээр яаж гарах нь вэ. Мэдээж өөр асуудал. Гол санаа нь болохлоор бид энэ хуулиараа ерөөсөө суурь зарчмууд, суурь хэм хэмжээг л тогтоож өгнө. Энэ бол ингээд яг гарцаагүй хуулиар тогтоосон хэм хэмжээ шүү. Үүнээс илүү юм уу. Үүнээс өөр асуудлууд гарах юм бол ажил олгогч, ажилтан хоёр хоорондоо зохицно шүү. Хоорондоо ярина шүү. Салбарынхаа хэмжээнд байх юм бол салбарын хэлэлцээр, байгууллагынхаа хэмжээнд байх юм бол одоо хамтын гэрээгээрээ ч юм уу. Ингэж зохицох л. Одоо нэг тийшээ харсан нэг баг болгох, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх.

Мэдээж ажил олгогч хүн бол хамгийн гол үнэтэй цэнтэй юм нь бол тэр туршлагатай, хариуцлагатай ажилтан л байгаа шүү дээ. Тийм ээ.

Тэгэхээр тэр хүнийгээ бэлдэж авах.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо санал хураалт явуулна. Шууд. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томилоод санал хураана. Зарчмын зөрүүтэй 22 санал байгаа.

Одоо гишүүд бүртгэлийн санал хураалт. Бүртгэлийн санал хураалт.

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Энэ 41 гишүүн бүртгэлд ороорой. Бүртгэлд ороогүй энэ 41 гишүүний нэрсийг дуудаж, мэдэгдээд зарлаад хяналтад оруулъя.

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зарчмын зөрүүтэй саналын анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн.

1.Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтын “хамтын сонирхлын маргааныг” гэснийг “хамтын сонирхлын маргаан, эсхүл энэ хуулийн 25.2-т заасан хөдөлмөрийн эрхийн маргааныг” гэж өөрчлөх.

Санал гаргасан Нийгмийн бодлогын байнгын хороо.

Энэ дэгийн тухай хуулийн ямар заалтаар үүнийг Нийгмийн бодлогын байнгын хороо. Хэрвээ чиглэл өгөөгүй бол ингэж санал гаргах эрх байхгүй шүү дээ. 42.3-аар юм уу? Тийм ээ.

Гуравны хоёроор бол гишүүн гаргаад дэмжсэн байх ёстой. Энэ дээр Нийгмийн бодлогын байнгын хороо гэсэн байна.

Чуулган дээр гуравны хоёр гэж байхгүй. 42.2.3-аар юм уу. Хасъя гэж байгаа юм уу? Байнгын хороо татаж байгаа юм уу?

Тэгвэл Ажлын хэсэг гэж явах ёстой шүү. Туршилтын санал хураалт явуулъя.

Энэ туршилтын санал хураалт байсан. Ингээд одоо санал хураалт явуулна. Саяын саналаар санал хураалт явуулъя.

Энэ Худалдаа, аж үйлдвэрийн танхим, Ажил олгогч эздийн холбоо, Үйлдвэрчний эвлэл гурвуулаа гурван талын зөвшилцөлд хүрсэн гэж ойлгож байгаа шүү дээ.

Тийм учраас ингээд хэлэлцээд батлаад явна. Сая энэ техникийн саатал гарсан учраас энэ санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Одоо санал хураалт явуулна. Энэ бэлтгэлийг хангачих. Санал хураалтыг дахиж явуулна. Санал хураалт. Түрүүн туршилт. Тэгээд сая бүртгэл. Тэгээд туршилтын санал хураалт явсан.

Тэгээд энэ техникийн саатал гараад микрофон ажиллахгүй байна гээд Ц.Мөнх-Оргил гишүүн санал хураалтаас өмнө нь хэлсэн учраас. Тэгээд техникийнхэн ч гэсэн техникийн сандал боллоо гэж хэлж байна. Одоо маргаан хэлэлцээ байхгүй.

63.4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.16 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.16.“хөдөлмөрийн эрхийн маргаан” гэж хөдөлмөрийн хууль тогтоомж, бүх төрлийн хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг хэрэгжүүлэх, эсхүл эдгээр хэм хэмжээг тайлбарлахтай холбоотойгоор талуудын хооронд үүссэн саналын зөрүүг;”

Санал гаргасан Нийгмийн бодлогын байнгын хороо. Санал хураалт.

66.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “Ажилтны төлөөлөгчид” гэсний өмнө “Ажилтан,” гэж, 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсгийн “зааснаас бусад тохиолдолд” гэсний дараа “ажил олгогч” гэж тус тус нэмэх.

Санал гаргасан. Нийгмийн бодлогын байнгын хороо. Санал хураалт.

Хуучин Хөдөлмөрийн хууль бол яг нөгөө социализмын үеэс уламжлагдсан харьцангуй нэг талынх байсныг бас талуудын зөвшилцлөөр дэвшилт алхам алхмаар орж байна. Төгс төгөлдөр юм, бүх хүний санал нийцсэн юм гэж хаа байх вэ. Ингээд гурван тал ойлголцсон юмыг одоо тэгээд хэл амгүй, маргаангүй батлаад явах нь зүйтэй.

63.4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Энэ Худалдаа, аж үйлдвэрийн танхим, Ажил олгогч эздийн холбоо тэгж байгаа юм. Ганц хүнд таалагдах албагүй.

Одоо ингээд Ж.Ганбаатар гишүүн олонхын саналаа хүндэтгэ. Цэндийн Мөнх-Оргил гишүүн дэмжсэн үг хэлнэ.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. 4 дүгээр санал дээр даргаа энэ нэр томьёог жигдэлж байгаа юм.

Тэгээд 30.2-ын “сонирхлын” гэдгийг хасаж байгаа юм. Яг үүнтэй адилхан 26.10-т бас “сонирхлын” гэдэг үгийг нэр томьёо жигдэлж хасах ёстой юм шүү. Манай Тамгын газрынхан үүнийг анхаараарай. Нэр томьёог жигдэлж байгаа юм.

Тэгэхээр дарга аа. Үүнийг 30.2, 26.10-аас “сонирхлын” гэдэг үгийг хасах гээд санал хураалгаад өгөөч ээ. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Энэ дээр Байнгын хорооны орж ирсэн саналаар санал хураах горим, дэгтэй. 30.2 дахь хэсгийн “сонирхлыг” гэснийг хасна гэж оруулчихаад.

Одоо энэ чинь эцсийн хэлэлцүүлэг шүү дээ. Тийм ээ. Эцсийн найруулга дээр найруулгаар тэр заалтыг авах чиглэл өгч байна./алх цохив/

Ингээд санал хураалт явуулъя.

66.2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Энэ санал дэмжигдсэн учраас саяын саналаар О.Номинчимэг дарга аа. Эцсийн найруулга уншихдаа найруулгын засвар хийх чиглэл эрхийг өгч байна.

5.Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 43 дугаар зүйлийн 43.2.9 дэх заалтын “хууль тогтоомжид заасны дагуу” гэсний дараа “ажлын байрны чиг үүрэгт хамаарах чиглэлээр” гэж нэмэх.

Санал гаргасан Нийгмийн бодлогын байнгын хороо. Санал хураалт.

С.Бямбацогт гишүүн. Санал хураалтыг хүчингүй болголоо. Санал хураалт явахгүй шүү. Сандагийн Бямбацогт гишүүн үг хэлнэ. Өөр үг хэлэх хүн бий юу? Алга байна.

**С.Бямбацогт:** Тэгээд нэлээн чухал хууль орж ирж байгаа. Нэлээн сайн ярилцаж байж баталж байгаа.

Тэгээд энэ үндсэндээ бол ажил олгогч, ажилтан, Засгийн газар энэ гурван талын зөвшилцөл дээр орж ирж байгаа. Үүнтэй холбогдуулаад бид бас Төрийн албаны хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага гарч байгаа. Энэ дээр цаашдаа Засгийн газар, Улсын Их Хурал анхаарах ёстой.

Сая Ц.Мөнх-Оргил гишүүн хэлсэн. Хөдөлмөрийн үнэлэмж, ижил ажил, албан тушаалд ажиллаж байгаа ижил үнэлэмжтэй хүмүүсийн хөдөлмөрийн үнэлэмж ойролцоо байх гэж. Яг үүнтэй адилхан энэ төрийн албанд өнөөдөр өнгө үзэмжээр томилогддог, ажил албан тушаалын шаардлага хангадаг, хангадаггүй. Зарим нь сонгон шалгаруулалтаар, зарим нь шууд лифтээр сууж томилогддог гэх мэтийн асуудлууд байгаа. Үүнийг цэгцлэх шаардлага байна.

Мөн ажилтнуудын цалин. Албан хаагчдын. Төрийн захиргааны албан хаагч нар гэхэд чинь ижилхэн үнэлэмжтэй ажил хийж байгаа мөртлөө өөр өөр цалин авдаг, урамшуулал авдаг. Төрийн тусгай албаныхан бас өөр өөр урамшуулалтай,

цалинтай. Төрийн үйлчилгээнийхэн бас өөр өө цалинтай, урамшуулалтай гээд асуудлууд байгаа.

Төрийн үйлчилгээнд одоо юу гэдэг юм багш, эмч нар байх ёстой юм уу, байх ёсгүй юм гэдэг асуудлыг ярих хэрэгтэй байна. Энэ ижил үнэлэмжтэй ажил албан тушаалд очиж байгаа хүмүүс ижилхэн цалинтай, ижилхэн урамшуулалтай, ижилхэн нэмэгдэлтэй байх ёстой. Тэгэхгүй бол одоо ерөөсөө өрсөлдөөн болчихсон. Онцгой нөхцөлийн нэмэгдэл, удаан жилийн нэмэгдэл, төрд ажилласны нэмэгдэл юу гэдэг юм гэх мэтээр бүгд л өрсөлдөөд нэмдэг болчихсон.

Энэ юмыг тэгээд дагалдуулж бид бас Төрийн албаны хуульдаа өөрчлөлт оруулж энэ төрийн албан хаагчдын ажил, албан тушаалд томилогдох, сонгогдох, ажлын үнэлэмж, цалин урамшуулал, тэр нэмэгдэл энэ бүгдийг жигдлэх шаардлага байгаа шүү. Үүнийг энэ дагалдах хуульдаа Улсын Их Хурлаас тогтоол гарах. Үүндээ оруулах ёстой гэдгийг протоколд зориуд тэмдэглэж хэлье.

Энэ зайлшгүй бид шийдэх ёстой асуудал мөн шүү гэдэг хэлье.

**Г.Занданшатар:** Энэ хөдөлмөрийн нөхцөл байдал өөр өөр байгааг жигдлэх, төрийн албаны хуулийн дагуу, ер нь өөрчлөлт оруулах, сонгон шалгаруулалтаас авхуулаад тэгш нөхцөл бий болгох гээд олон асуудлууд бас төрийн албан дээр энэ хуулийн дагуу хийгдэх ёстой гэж.

Энэ дагаж гарч байгаа дагаж мөрдөх тогтоол, хэрэгжүүлэх тогтоол дээрээ туссан гэж бодож байгаа шүү дээ. Тийм үү. Тэрийгээ анхаараарай.

Санал хураалт. Тав дахь санал хураалт.

50 гишүүн дэмжиж, 70.4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

6. Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 63 дугаар зүйлийн 63.3 дахь хэсгийн “Дагалдангаар суралцах ажилтны” гэсний дараа “ажил олгогчоос болон ажилтнаас төлөх” гэж нэмэх.

Санал гаргасан: Нийгмийн бодлогын байнгын хороо. Санал хураалт явахгүй. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн үг хэлнэ.

**Б.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Бид товчхон хоёр зүйл хэлье. Өглөөнөөс хойш энэ тахалтай холбоотой хууль, бусад хуулиуд дээр асуулт асуух гээд, үгүй хэлэх гээд энэ цахимаар сайн орж өгөхгүй юм.

Тэгээд энэ Хөдөлмөрийн хууль бол чухал хууль байгаа. Дэмжиж байгаа. Тэгээд энэ дээр би нэг хоёр зүйл асуух гэсэн юм. Нэгд нь энэ уул уурхайн үйлдвэрлэлтэй холбоотой. Уул уурхай бол эдийн засгийн гол тулгуур гэдэгтэй хэн ч маргахгүй. Нэг.

Нөгөө талдаа энэ уул уурхай эрхэлж байгаа компаниудын ажил...

**Г.Занданшатар:** Одоо дэмжсэн дэмжээгүй санал хэлнэ. Асуулт байхгүй.

**Б.Бат-Эрдэнэ:** ...Цаашлах юм бол хордлого, аюул осолтой холбоотой хөдөлмөрийн чадвараа алддаг, мэргэжлээс шалтгаалан шалтгаалах өвчний байдлаар ингээд группэд ордог. Энэ хүмүүсийн асуудлыг яаж зохицуулж байгаа вэ? Энэ дээр их тодорхой зохицуулалт хийхгүй бол энэ цаашдаа ч гарах юм байна лээ.

Өмнө нь энэ Бэрх, Бүрэнцогтоос өгсүүлээд Налайх, Бор-Өндөр энэ уул уурхайд ажиллаж байсан ажиллагсдын тэтгэмжтэй холбоотой юмыг бол нэг шийдсэн.

Одоо ингээд хувийн гадаад дотоодын хөрөнгө оруулалттай уул уурхайн компаниуд үйл ажиллагаа явуулж байгаа учраас энд ажиллагсдын эрх ашиг зөрчигдөх, эрүүл мэнд, амь насаараа хохирох, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан хүмүүсийг нийгмийн хамгаалал, баталгаатай холбоотой юмыг яаж зохицуулж байгаа вэ гэдэг юмыг бол би хэлэх гэж байгаа юм.

Харин сайшаалтай нь А.Ариунзаяа сайд манай Бор-Өндөрийн мэргэжлээс шалтгаалах хөдөлмөрийн чадвараа алдсан хүмүүсийн эрх ашгийг хамгаалах энэ төрийн бус байгууллагатай их сайн холбогдож ажиллаж байгаа явдалд баяртай байгаа.

Тэгэхээр энэ хуульд л хамгийн гол зохицуулалт нь байхгүй бол нэг удаагийн арга хэмжээ аваад нөхөн олговор олгоод энэ асуудал өөрөө шийдэгдэхгүй юм байна лээ шүү дээ. Нэг ийм зүйл.

Нөгөөдөх нь сая С.Бямбацогт гишүүний хэлж байгаагаар холбоотой. Ялангуяа энэ төрийн албан хаагчид энэ салбаруудын цалин хангамж, нийгмийн баталгаа тийм ялгамжгүй байх чиглэлийн юмыг бодохгүй бол түрүүн Ц.Мөнх-Оргил сайдын хэлж байгаа чадамжтай нь уялдуулж цалин ялгамжтай байх нь бол ойлгомжтой. Гэхдээ төрийн албан энэ салбаруудын хоорондын уялдааг хангахгүй бол энэ цаашдаа маш хүнд байдал руу орох юм байна лээ шүү. Энэ КОВИД-ын улмаас маш олон мянган хүн, мянган аж ахуй нэгжүүд үүд хаалгаа барьсан, ажлын байраа алдсан гэж байгаа юм. Энэ чинь энэ ялгамжтайгаар зохицуулаад нэг салбарын хуульд нийгмийн хамгаалал, цалин хөлсийг ялгамжтай оруулж ирж байгаагаас болоод энэ чинь хувийн хэвшил, аж ахуйн нэгж байгууллага маш хүнд цохилт бий болж байгаа юм шүү. Үүнийгээ та нар бодож үзсэн юм биз дээ гэж. Би ийм зүйлийг хэлье. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Баярлалаа. Үг хэллээ. Дэгээрээ санал хураалтын үед дэмжсэн, дэмжээгүй гурав хүртэл гишүүн үг хэлнэ. Асуулт байхгүй.

Саяын таны хэлсэн санаанууд хуулийн төсөлд тусгасан гэдгийг ажлын хэсгээс түрүүн хариулсан. Бусад асуудлыг Төрийн ба албаны хууль, бусад холбогдох хуулиудтай дагалдаж гарах хуулиудаар хэлэлцэж шийдвэрлэхэд нь саналаа өгцгөөгөөрэй. Ингээд санал хураалт явуулъя.

59.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсгийн “бүтээгдэхүүн” гэснийг хасах.

Санал гаргасан Нийгмийн бодлогын байнгын хороо. Санал хураалт.

65.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

8.Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 72 дугаар зүйлийн 72.3 дахь хэсгийн “үйлчлэх хугацаа” гэсний дараа “нь ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгавар болсноос хойш” гэж нэмэх.

Санал гаргасан Нийгмийн бодлогын байнгын хороо. Санал хураалт.

65.7 хувийн саналаар энэ санал дэмжүүлээ.

9.Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 79 дүгээр зүйлийн 79.4 дэх хэсгийг хасах.

Санал гаргасан Нийгмийн бодлогын байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалтад 70 гишүүн оролцож, 46 гишүүн дэмжиж, 65.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

10.Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсгийн “ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцааг” гэсний дараа “энэ хуульд зааснаас бусад үндэслэлээр” гэж нэмэх.

Санал гаргасан Нийгмийн бодлогын байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалтад 70 гишүүн оролцож, 48 гишүүн дэмжиж, 68.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 83 дугаар зүйлийн 83.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“83.5.Ажилтанд энэ хуулийн 83.3-т заасан хугацааны цалин хөлсийг ажил олгогч тооцож олгоно.”

Санал гаргасан Нийгмийн бодлогын байнгын хороо. Санал хураалт.

68.6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

12.Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 85 дугаар зүйлийн 85.2 дахь хэсгийн “ажлын байранд” гэснийг хасах.

Санал гаргасан Нийгмийн бодлогын байнгын хороо. Санал хураалт.

70.0 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

13.Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 92 дугаар зүйлийн 92.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“92.5.Энэ хуулийн 92.4-т заасан хугацааг багасгах тохиолдолд ажил үүрэг гүйцэтгэх, амрах хугацаа нь тэнцүү байхаар ажил олгогч, ажилтны төлөөлөгч харилцан тохиролцож болно.”

Санал гаргасан Нийгмийн бодлогын байнгын хороо. Санал хураалт.

70.0 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

14.Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 99 дүгээр зүйлийн гарчгийн “Ээлжийн амралт” гэсний дараа “, түүний хугацаа” гэж, 99.3 дахь хэсгийн “ажилтны” гэсний өмнө “Хуульд өөрөөр заагаагүй бол” гэж тус тус нэмж, 99.3 дахь хэсгийн “ажлын 20 өдөр” гэснийг “ажлын 15 өдөр” гэж, 99.4 дэх хэсгийн “ажлын 25 өдөр” гэснийг “ажлын 20 өдөр” гэж, 99.9 дэх хэсгийн “Төрийн албан хаагчийн ээлжийн” гэснийг “Ажил мэргэжлийн онцлогийг харгалзан” гэж тус тус өөрчилж, 99.8 дахь хэсгийг хасаж, мөн зүйлийн 99.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“99.6.Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллаж байгаа ажилтанд түүний ажилласан хугацааг харгалзан ээлжийн үндсэн амралтын хугацаан дээр нь доор дурдсан нэмэгдэл амралтыг олгоно:

99.6.1. 6 дахь жилийн эхнээс 10 дахь жилийг дуусталх хугацаанд ажлын 5 өдөр;

99.6.2. 11 дэх жилийн эхнээс 15 дахь жилийг дуусталх хугацаанд ажлын 7 өдөр;

99.6.3. 16 дахь жилийн эхнээс 20 дахь жилийг дуусталх хугацаанд ажлын 9 өдөр;

99.6.4. 21 дэх жилийн эхнээс 25 дахь жилийг дуусталх хугацаанд ажлын 12 өдөр;

99.6.5. 26 дахь жилийн эхнээс 31 дэх жилийг дуусталх хугацаанд ажлын 15 өдөр;

99.6.6. 32 дахь жилээс ажлын 18 өдөр.”

Санал гаргасан Нийгмийн бодлогын байнгын хороо. Санал хураалт.

67.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

15.Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 99 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 99.5 дахь хэсэг нэмэх:

“99.5.Хөдөлмөрийн хэвийн нөхцөлд ажиллаж байгаа ажилтанд түүний ажилласан хугацааг харгалзан ээлжийн үндсэн амралтын хугацаан дээр нь доор дурдсан нэмэгдэл амралт олгоно:

99.5.1. 6 дахь жилийн эхнээс 10 дахь жилийг дуусталх хугацаанд ажлын 3 өдөр;

99.5.2. 11 дэх жилийн эхнээс 15 дахь жилийг дуусталх хугацаанд ажлын 5 өдөр;

99.5.3. 16 дахь жилийн эхнээс 20 дахь жилийг дуусталх хугацаанд ажлын 7 өдөр;

99.5.4. 21 дэх жилийн эхнээс 25 дахь жилийг дуусталх хугацаанд ажлын 9 өдөр;

99.5.5. 26 дахь жилийн эхнээс 31 дэх жилийг дуусталх хугацаанд ажлын 11 өдөр;

99.5.6. 32 дахь жилээс ажлын 14 өдөр.”

Санал гаргасан Нийгмийн бодлогын байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалтад 70 гишүүн оролцож, 49 гишүүн дэмжиж, 70.0 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

16.Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 104 дүгээр зүйлийн 104.7 дахь хэсгийн “цалин хөлс, олговрыг” гэсний дараах “олгоогүй, эсхүл” гэснийг хасах.

Санал гаргасан Нийгмийн бодлогын байнгын хороо. Санал хураалт.

70 гишүүн оролцож, 48 гишүүн дэмжиж, 68.6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

17.Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 107 дугаар зүйлийн 107.2 дахь хэсгийн “хамтын хэлэлцээрээр зохицуулна” гэснийг “хамтын хэлэлцээрээр зохицуулж болно” гэж өөрчлөх.

Санал гаргасан Нийгмийн бодлогын байнгын хороо. Санал хураалт.

48 гишүүн дэмжиж, 67.6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

18.Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 123 дугаар зүйлийн 123.7 дахь хэсгийн “Ажил олгогч сахилгын зөрчлийн шинж, үр дагаврыг харгалзан энэ хуулийн 114.1 дэх хэсэгт заасан сахилгын шийтгэлийг сонгож хэрэглэнэ.” гэсэн 2 дахь өгүүлбэрийг хасах.

Санал гаргасан Нийгмийн бодлогын байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалтад 71 гишүүн оролцож, 46 гишүүн дэмжиж, 64.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

19.Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 154 дугаар зүйлийн 154.11 дэх хэсгийн “эсхүл шийдвэрийг” гэснийг “эсхүл шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш” гэж өөрчилж, мөн хэсгийн “хүлээн авснаас хойш” гэснийг хасах.

Санал гаргасан Нийгмийн бодлогын байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалтад 71 гишүүн оролцож, 52 гишүүн дэмжиж, 73.2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

20.Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 166 дугаар зүйлийн 166.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Санал гаргасан Нийгмийн бодлогын байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалтад 71 гишүүн оролцож, 50 гишүүн дэмжиж, 70.4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хоёр. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Нэг.Төрийн албаны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн “Төрийн албан хаагчид олгох ээлжийн нэмэгдэл амралт” гэсэн 61<sup>1</sup> дүгээр зүйлийг хасах.

Санал гаргасан Нийгмийн бодлогын байнгын хороо. Санал хураалт.

Төрийн албаны хууль гэдгийн дараа Шинэчилсэн найруулга гэж байхгүй шүү.

64.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Түрүүчийнх шиг нөгөө урт хугацааны нэмэгдлүүд нь өөрчлөхгүй юм уу? Тийм ээ.

Хоёр. Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах.

Санал гаргасан Нийгмийн бодлогын байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалтад 71 гишүүн оролцож, 50 гишүүн дэмжиж, 70.4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүллээ.

Дараагийн асуудалд орно.